



## АГУУЛГА

БҮЛЭГ I. ТӨСЛИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ.....	2
Төслийн хүчин чадал.....	3
Ил уурхайн ашиглалтын технологи .....	4
БҮЛЭГ II. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН СУУРЬ НӨХЦӨЛ.....	5
Гадаргын нөхцөл.....	5
БҮЛЭГ III. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ .....	8
БҮЛЭГ 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....	10
Уурхайн карьерт орж гарах машин, ачилт буулгалтын цаг хугацаа, хоорондын зайг уурхайн даргын удирлаган доор удирдуулан тээвэрлэсэн. ....	10

## БҮЛЭГ I. ТӨСЛИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ


**Төслийн нэр:** “Баруун харганат” нэртэй MV-021465 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайн алтны үндсэн орд

**Төсөл хэрэгжүүлэгч:** “Би Эс Ай” ХХК регистрийн дугаар: 5035503 Улсын бүртгэлийн дугаар 9019013029

**Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:** Улаанбаатар хот, Багануур дүүрэг, 3-р хороо 48-18 тоот, Утас 99117592

**Төслийн байршил:** “Баруун харганатын” алтны орд нь нь засаг захиргааны нэгжийн хувьд Баянхонгор аймгийн Өлзийт сумын нутагт харъяалагддаг ба Улаанбаатар хотоос 665 км, Баянхонгор аймгийн төвөөс 25 км, Өлзийт сумын төвөөс 14 км зайд MV-021465 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд оршино. Төслийн талбайн солбицолын цэгүүдийг доорх хүснэгтэнд, байршлыг доорх зурагт тус тус үзүүлэв.

Зураг 1. Төслийн талбайн байршил



**Хүснэгт 1. Тусгай зөвшөөрлийн талбайн булангийн цэгүүд**

№	Тэгш өнцгийн солбицол /UTM/	
	X/м/	Y/м/
1	654874.409	5096040.619
2	655118.762	5086323.982
3	651494.058	5086234.119
4	651474.679	5087025.112
5	648129.373	5086944.053
6	648060.367	5089823.489
7	647705.561	5089814.994
8	647663.201	5091586.177
9	647034.720	5091571.176
10	647010.843	5092573.583
11	645917.420	5092547.634
12	645840.002	5095821.207

**Төслийн хүчин чадал**

Баруун Харганат алтны шороон ордоос жилд 37.97 мян.м<sup>3</sup> элс олборлох хүчин чадал бүхий ил уурхайг ажиллуулахаар төлөвлөв. Нийт үйлдвэрлэлийн нөөц 63.87 мян.м<sup>3</sup> элс байна. MV-021465 тоот ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд хамаарах Баруун Харганат алтны шороон ордын нөөцийг ашиглалтын эхний 1-р жилд 37.97 мян.м<sup>3</sup> элс, 2-р жилд 25.89 мян.м<sup>3</sup> элс олборлохоор 2 жилийн хугацаанд төлөвлөв. Ашиглалтын хугацаанд 322.51 мян.м<sup>3</sup> хөрс хуулж, 63.87 мян.м<sup>3</sup> элс олборлож, шлихээр 34.24 кг, химийн цэврээр 32.97 кг алт олборлохоор байна.

**Хүснэгт 2. Ашиглалтын жилүүдийн хөрс хуулалт, олборлолтын хэмжээ**

Блокийн дугаар, нөөцийн зэрэглэл	Үйлдвэрлэлийн нөөц				
	Хөрсний хэмжээ, мян.м <sup>3</sup>	Олборлох элсний хэмжээ, мян.м <sup>3</sup>	Дундаж агуулга, мг/м <sup>3</sup>	Алт	
				Шлихээр	Химийн цэврээр
В-1	122.81	27.12	667.47	18.10	17.43
В-2	66.18	10.85	800.89	8.69	8.37
С-1	133.52	25.89	287.64	7.45	7.17
<b>Бодитой В</b>	<b>188.99</b>	<b>37.97</b>	<b>705.60</b>	<b>26.79</b>	<b>25.80</b>
<b>Боломжтой С</b>	<b>133.52</b>	<b>25.89</b>	<b>287.64</b>	<b>7.45</b>	<b>7.17</b>
<b>Нийт /В+С/</b>	<b>322.51</b>	<b>63.87</b>	<b>536.14</b>	<b>34.24</b>	<b>32.97</b>

Ордын хэмжээнд 319.7 мг/м<sup>3</sup> дундаж агуулгатай 6.2 мян.м<sup>3</sup> элс, шлихээр 1.38 кг алт, химийн цэврээр 1.33 кг алтны нөөц ил уурхайн хүрээний гадна үлдэж байна. Уурхайн хажуугаас нийтдээ 9.67 мян.м<sup>3</sup> хөрс нэмэгдэхээр байна.

**Уурхайн ажиллах горим**

Уурхайн ажиллах горимыг уурхайн хүчин чадал, жилд гүйцэтгэх уулын ажлын хэмжээ, өвлийн улирлын үргэлжлэх хугацаа зэргээс хамааруулан 05 сараас 10 сар дуустал буюу 6 сарын хугацаанд, 12 цагийн 2 ээлжээр ажиллана. Уурхайн жилд ажиллах хоног 180 хоног, буюу 2880 цаг байна.

Үйлдвэрлэлийн бусад ажил болох цахилгаан хангамж, усан хангамж, гэрэлтүүлэг, усан сан байгуулах болон угаах төхөөрөмж /скруббер/ зэргийг угсарч монтажлах ажлуудыг дотоод ажлын зохион байгуулалтаар гүйцэтгэнэ.

**Хүснэгт 3. Уулын ажиллах горим**

№	Гормын үзүүлэлт	Хэмжих нэгж	Хэмжээ
1	Хуанлийн	хоног	180
2	Баяр ёслол	хоног	4
3	Төлөвлөгөөт засвар үйлчилгээ	хоног	5
4	Уурхайн жилд цэвэр ажиллах хоног	хоног	171
5	Хоногт ажиллах ээлжийн үргэлжлэх хугацаа	цаг	12
6	Ээлжийн тоо	ш	2
7	Ээлжийн үргэлжлэх хугацаа, цаг	цаг	12
8	Ээлжин дэх сул зогсолт (үдийн цай, тос түлш нэмэх)	цаг	1
9	Ээлжийн бэлтгэл, төгсгөл	цаг	0.5
10	Өдрийн сул зогсолт	цаг	1
11	Бүтээлтэй ажиллах цаг	цаг	9.5
12	Цаг ашиглалт		0.88
13	Жилд ажиллах нийт цаг	цаг	4104

**Ил уурхайн ашиглалтын технологи**

Ордын уул геологийн нөхцөл, ашиглалтын систем, уурхайн тоног төхөөрөмж, тэдгээрийн хүчин чадал, зэргийг харгалзан экскаватор, автосомасвалын хослол, блок нээх үед бульдозероор түрж, хөрсний гадаад овоолго, элсний дотоод овоолго үүсгэн ашиглах боломжтой гэж үзлээ. Дээрх ашиглалтын системийг Баруун Харганат алтны шороон ордын хэмжээнд ашиглана.

Элс баяжуулах ажилд “NG050” маркийн скруббер ашигласнаар элс болон хөрсийг богино зайд тээвэрлэж, уурхайн ашигласан орон зайг дотоод овоолгоор дүүргэж, техникийн нөхөн сэргээлтийн ажлыг нэгэн зэрэг хийх юм. Энэ нь уурхайн нөхөн сэргээлтийн ажлыг богино хугацаанд хийх нөхцөлийг бүрдүүлж байна.

Баруун Харганат алтны шороон ордын ашиглалтын үндсэн процессууд:

- Үржил шимт өнгөн хөрс хуулалтын ажил
- Хөрс хуулалтын ажил
- Элс олборлолтын ажил
- Элс угаалтын (баяжуулалтын) ажил
- Хөрсний овоолгын тэгшлэлтийн ажил
- Техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн ажил

Баруун Харганат алтны шороон ордын уул-техникийн нөхцөлөөс хамаарч авто тээвэртэй, дотоод овоолго бүхий ашиглалтын системийг ашиглана.

	Процессууд (тоног төхөөрөмж)		
<b>Шимт хөрс хуулалт</b>	Ухаж түрэх	Овоолох	
	Бульдозер	Бульдозер	
<b>Хөрс хуулалт</b>	Ухаж ачих	Овоолго	
	Экскаватор, Автосамосвал	Автосамосвал, Бульдозер	
<b>Элс олборлолт</b>	Ухаж ачих	Овоолго	Ухаж ачих
	Экскаватор	Автосамосвал	Угаах төхөөрөмж



## БҮЛЭГ II. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН СУУРЬ НӨХЦӨЛ

### Гадаргын нөхцөл

Тусгай зөвшөөрлийн талбай нь Баянхонгор аймгийн Өлзийт сумын нутаг дэвсгэр дээр оршдог.

*Газрын гадарга, байр зүй:* Хэнтийн нуруу ба түүний гол салбаруудын тойрог нь Хэнтийн гол нуруу, Бага Хэнтий, Их Хэнтийн нуруу, тэдгээрийн томоохон салбаруудыг багтаана. Эндхийн үнэмлэхүй өндөр нь 2000-2500 метр бөгөөд хамгийн өндөр цэг нь Асралт Хайрхан юм. Хэнтийн нурууд ялангуяа Бага Хэнтийн нурууны хажуу нь хоорондоо адилгүй, хойт хажуу нь маш эгц бөгөөд урт, харин өмнө хажуу нь нилээн налуувтар болно. Гэвч хоёулаа нураг асгаар бүрхээстэй байна. Хажуугийн дээд хэсэгт шаталсан хэдэн дэнж тодорхой үзэгдэнэ.

*Тойргийн хилийг тоймлон заавал:* Зүүн талд Барах голын адаг орчмоор гарч өмнө хэсэгтээ Хурах, Туул голыг дагасан тектоникийн гаралтай хөндийнүүд болон Улаанбаатар хотоос нилээн хойгуур гарах ба баруун гар талдаа Хараа голын баруун гарын цутгалуудыг огтлон гарсан шугам, хойт талд улсын хил болно. Тэр хөндийнүүдээр эртний мөсөн гол урсан бууж байсны ор мөр болох морены дов толгод, далан, дэнж, хаагдсан нуур тохиолдоно. Хэнтийн гол нуруудын захаар байгаа хөндийнүүд 1-3 км өргөн, хажуунууд мөн эгц болоод асгаар бүрхээстэй байна. Энэ тойрог чийг тунадас ихтэй учраас намаг ихтэй, гол горхиуд усаар элбэг, уналт их, урсгал түргэн байдаг.


### Хөрс

“Монгол орны хөрс” /Акад. Д.Доржготов, 2003/ номноос төслийн талбайд тархсан зонхилох хэв шинжийн хөрсний үндсэн шинж чанарын талаарх товч тодорхойлолтыг орууллаа.

Хөрс газарзүйн хувьд сав газрын хойт хэсэг нь Хэнтийн нурууны төв хэсгийн уулын тундрын болон уулын нугын хөрсний тойрогт, нутгийн дунд болон түүнээс хойш хэсэг нь Хэнтийн нурууны зүүн ба баруун хэсгийн салбар уулсын уулын хар хүрэн ба хээрийн хар хүрэн хөрсний тойрогт, хэсэг нь хуурай хээрийн бүсийн ухаа гүвээт, удам хөндийн хүрэн хөрсний тойрогт ордог.



Зураг 1. Төслийн талбайн хөрсөн бүрхэвч



**Зураг 2. Төсөл хэрэгжих орчны хөрс газарзүйн ангилал**

### Уур амьсгал

Төслийн талбай орчмын нутгийн уур амьсгалын онцлог: Төслийн талбай орчимд зуны улиралд эх газрын дулаан хуурай агаар зонхилдог. Иймээс орох хур тунадас ихэнхдээ аадар шинжтэй байдаг. Намар хур тунадас багасаж, цочир хүйтрэлт 8 дугаар сарын сүүлч, 9 дүгээр сарын эхээр ажиглагдсан 10 дугаар сарын сүүлч, 11 дүгээр сарын эхээр өвлийн нөхцөлдөө шилжин ордог.

Агаарын температур: Баянхонгор аймгийн нутаг нь хангай, тал хээр, говь хосолсон уудам дэлгэр нутагтай тул дулаан хүйтний хэлбэлзэл ихтэй сүүлийн жилүүдийн байдлаар нийт нутгаар жилийн дундаж агаарын температур дундажаар 2.00C дулаарсан хэдий ч улирлаар нь авч үзвэл: Ихэнх нутгаар өвлийн улиралд 1.4-өөс 2.5 градус, хавар зуны улиралд 0.2-оос 1.0 градусаар дулаарсан, нутгийн өмнөд хэсгээр өвлийн улиралд -0.2-оос -2.0 хүйтэрсэн хэдий ч зуны улиралд 2.0 градусаар дулаарч ажиглагдаж байна.

### Агаарын чанарын ерөнхий төлөв байдал:

Тэсэлгээ хийх, хөрс хуулах, төслийн талбайгаас уурхайд ашиглагдаж байгаа хүнд даацын техникүүдийн дизель түлшний шаталтын дүнд ялгарсан утаа, хорт хий агаарыг бохирдуулах магадлалтай. Ажлын явцад олон салаа зам үүссэнээс орчин тойрны ургамал их хэмжээгээр талхлагдаж, хөрс эвдрэлд орсноор агаарын хөдөлгөөний харьцангуй бага утгын нөлөөгөөр тоосжилт үүснэ.

Баянхонгор аймгийн агаарын чанарын харуул нь агаарт агуулагдах хүхэрлэг хий /SO<sub>2</sub>/, азотын давхар исэл /NO<sub>2</sub>/-ийн хэмжээг ажлын өдрүүдэд, тоосонцор /PM<sub>10</sub> /-ын хэмжээг 7 хоногт 2 удаагийн давталттайгаар хэмжин тодорхойллоо. Өнгөрсөн 7 хоногийн хүхэрлэг хий, азотын давхар исэл, тоосонцорын агууламжийг тус бүрд нь стандарттай харьцуулсныг хүснэгтээр харуулав.

NO <sub>2</sub> Азотын давхар исэл (мг/м <sup>3</sup> ) <i>/Стандарт: 0.200/</i>	SO <sub>2</sub> Хүхэрлэг хий (мг/м <sup>3</sup> ) <i>/Стандарт: 0.450/</i>	PM <sub>10</sub> (мг/м <sup>3</sup> ) <i>/Стандарт: 0.100/</i>	CO (мг/м <sup>3</sup> )
0.039	0.047	-	
0.027	-	-	

2023 оны 2 дугаар сарын 1-10 хоногийн байдлаар агаарын чанарын үзүүлэлтүүдийн агууламж өмнөх 10 хоногоос бага зэрэг нэмэгдсэн. Бохирдлын агууламж MNS4585:2016 стандартын зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс давсан тохиолдолгүй. Бохирдлын агууламжаар хүхэрлэг хийн агууламж 0.002мг/м<sup>3</sup>-ээр, азотын давхар исэл 0.002мг/м<sup>3</sup> –ээр, нэмэгдсэн байна. PM<sub>10</sub> тоосонцрын агууламж өмнөх 10 хоногоос нэмэгдсэн MNS4585:2016 стандартын зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс давсан тохиолдол байхгүй байна.

### БҮЛЭГ III. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

Тус төслийн үйл ажиллагааны улмаас хүрээлэн буй орчинд учрах болзошгүй нөлөөллийг тогтоохдоо байгаль орчны суурь нөхцөл, урьд өмнө хийгдсэн байгаль, нийгэм, эдийн засгийн холбогдолтой судалгааны материалууд, судалгаа явуулсан мэргэжлийн экспертүүдийн дүгнэлтүүдийг үндэслэн тодорхойлов. Төслийн үйл ажиллагаанаас сөрөг нөлөөлөлд өртөгдөх байгалийн үндсэн тусгагдахуун нь газрын хэвлий, газрын гадарга, агаар, хөрс, ургамал, амьтан юм.

Уурхайн үйл ажиллагаанаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг тогтоох зорилгоор шинжээчдийн хэсэг газар дээр нь очиж, төсөл хэрэгжих талбай болон орчны байдал, ТЭЗҮ-тэй танилцаж, холбогдох судалгааг хийсэн болно.

Төслийн болзошгүй нөлөөллийг тогтоохдоо магадлан жагсаах аргыг ашиглаж, үр дүнг дараах хүснэгтэд үзүүлэв. Энэ арга нь төсөл хэрэгжих үед тухайн нөлөөлөл байгаа эсэх дээр тулгуурладаг ба хэрэв тухайн нөлөөлөл байвал "х"-ээр тэмдэглэдэг. Ингэхдээ тухайн нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим зэргийг тодруулах, мөн уг нөлөөлөл байгаль орчин, экологийн тэнцвэрт байдал, орон нутгийн нийгэм-эдийн засагт хэрхэн нөлөөлөх (шууд, шууд бус, эргэж нөлөөлөх, буцалтгүй нөлөөлөх, давхардах эсэх) байдлыг үзүүлдэг.

**Хүснэгт 5. Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлж болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим нь нөлөөллийн төрлийн уялдаа**


№	Нөлөөллийн төрөл	Нөлөөллийн эрчим									
		Хэлбэр	Хугацаа	Нөлөөллийн эрчим							
		Шууд	Шууд бус	Богино	Урт	Буцаж нөлөөлөх	Буцалтгүй нөлөөлөх	Өөрөө зохицуулах	хүчтэй	Дунд зэрэг	Сулавтар
<b>1. Байгаль орчин, экосистемийн өөрчлөлт</b>											
1	Газрын доорх усны урсац өөрчлөгдөх										х
2	Гадаргын усны урсац өөрчлөгдөх										
3	Ургамлан нөмрөг өөрчлөгдөх	х		х		х	х			х	
4	Хөрсний элэгдэл, эвдрэл ихсэх	х		х			х			х	
5	Геологийн тогтоц өөрчлөгдөх	х			х				х		
6	Зэрлэг ан амьтдын байршилт, тархалт өөрчлөгдөх	х		х			х	х			х
7	Уур амьсгал(бичил)-ын өөрчлөлт			х			х	х			х
<b>2. Байгалийн нөөцийн ашиглалт</b>											
8	Эрдэс түүхий эдийн нөөц хомсдох	х								х	
9	Бэлчээрийн талбай хомсдох	х			х	х		х		х	
10	Үйл ажиллагаанаас усны нөөц хомсдох	х									
11	Ахуйн зориулалтаар ашигласнаас усны нөөц хомсдох	х									
12	Эрчим хүчний хэрэглээ нэмэгдэх /үйлдвэрийн хэрэгцээнд/	х									х
13	Эрчим хүчний хэрэглээ нэмэгдэх /ахуйн хэрэгцээнд/	х			х					х	х
<b>3. Байгаль орчны чанарын өөрчлөлт</b>											
14	Газрын доорх усны чанар өөрчлөгдөх		х		х		х				х
15	Гадаргын усны чанар өөрчлөгдөх		х				х			х	



**“БИ ЭС АЙ” ХХК-ИЙН БАЯНХОНГОР АЙМГИЙН ӨЛЗИЙТ СУМЫН НУТАГТ ОРШИХ “БАНУУН ХАРГАНТЫН” АЛТНЫ ШОРООН ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ МЕНЕЖМЕНТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

16	Агаарын бохирдол үүсэх	x								x	
17	Хөрсний бохирдол үүсэх		x	x			x			x	
18	Дуу чимээ, доргио чичиргээний нөлөөлөл	x		x		x				x	
<b>4. Байгалийн өнгө төрх, түүх соёлын дурсгалт зүйл, археологи, палеонтологийн олдвор</b>											
19	Байгалийн унаган төрх болон ландшафтын хэлбэр төрх өөрчлөгдөх	x									
20	Тусгай хамгаалалттай газар нутагт нөлөөлөх	x			x		x				x
21	Түүх, соёлын дурсгалт зүйлд нөлөөлөх										
22	Археологи, палеонтологийн олдворт нөлөөлөх										
<b>5. Бусад нөлөөлөл</b>											
23	Үйлчилгээний үйл ажиллагааг хангахтай холбоотойгоор байгаль орчин элэгдэл доройтолд орох (барилга байгууламж, асфальтан зам, эрчим хүч, дулаан, цэвэр, бохир усны нэгдсэн системд холбогдох шугам татах, суваг шуудуу ухах зэрэг)	x			x		x				x
24	Ахуйн бохир ус, нефьтийн бүтээгдэхүүн, химийн бодис асгаран хөрсөнд нэвчиж, хөрс ба грунтын ус бохирдуулах	x			x		x				x
25	Хатуу хог хаягдлын цэгийн байрлал, ил задгай байлгах болон шингэн хаягдлын шугам хоолой, түүний дамжуулах хоолойд гэмтэл гарах тохиромжгүй байдал (үнэр) үүсэх	x		x			x				x
32	Барилгын ажлын хатуу, шингэн хаягдлаар байгаль орчин бохирдох	x			x		x				x
33	Хүчтэй салхи, түймэр, газар хөдлөл, аянга		x		x		x				x
	Дүн	25	6	0	3	21	4	20	3	12	9

Дээрх хүснэгтээс харахад тус төслийн үйл ажиллагааны явцаас байгаль орчинд нөлөөлөх нөлөөлөл өөр хоорондоо харилцан уялдаа холбоотой нэг нь нөгөөдөө шууд буюу дам байдлаар нөлөөлөх нь харагдаж байна.



Тус ордыг ашиглах төслийн үйл ажиллагаанаас сөрөг нөлөөллийг байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг тус бүрд үзүүлэх ба 7.1% нь “бага”, 45.2% нь “дунд”, 42.8% нь “их”, 4.8% нь “маш их” гэсэн нөлөөллийн үнэлгээний зэрэгт хамаарагдаж байна. Нөлөөлөлд өртөж буй байгалийн бүрэлдэхүүн хэсгүүдээс газрын гадарга, хэвлий нь нөлөөлөлд илүүтэйгээр өртөхөөр байна.

### БҮЛЭГ 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

“Би эс ай” ХХК нь Баянхонгор аймгийн Өлзийт сумын нутагт орших “Баруун харгантын” алтны шороон ордыг ил аргаар ашиглах төслийн хүрээнд 2023 онд уулын ажилд 1.1 га талбайд олборлолт явуулж, 1.1 га талбайд техникийн нөхөн сэргээлт, аймаг, сум орон нутагтай хамтран ажиллаж тохижуулалт, иргэдэд дэмжлэг үзүүлж дэмжиж ажиллах /15.0 сая.төг/, мөн нинжа нарын гараар эвдэрсэн газарт нөхөн сэргээлт, хог хаягдлыг цэвэрлэх, уурхайн хүрээнд ажилчдыг сургалтанд хамруулах, техник технологийн үзлэг, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр зэрэг ажлуудыг хийсэн байна. Эдгээр ажлуудыг дараах хүснэгтээр дэлгэрэнгүйгээр орууллаа.

**Хүснэгт № 6 Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт**

№	Арга хэмжээ	Үйл ажиллагааны хамрах хүрээ	Нэгжийн өртөг, төг	Хэрэгжүүлсэн хувь	Сөрөг нөлөөлөл
<b>Агаар</b>					
1	Уурхайн тоног төхөөрөмж, авто тээврийн хэрэгслээс үүсэх хорт хийн ялгарлыг бууруулахын тулд ашиглагдаж байгаа тээврийн хэрэгсэлд утааны шүүлтүүрүүдийн бүрэн бүтэн байдлыг шалгаж, тос, маслыг тогтоосон хугацаанд нь солих	Уурхайн тоног төхөөрөмж	450000	100%	Эскватор, утгуурт ачигч, автосамосвал, түлшний машин тус тус ажиллаж байсан. Эдгээр техникүүдийн тос маслыг 2023 оны 5,10 сард 1 удаа сольсон.
2	Агаарын тоосжилтыг бууруулах зорилгоор дотоод тээврийн замыг тогтмол услах	Дотоод тээврийн замын хүрээнд	-	100%	Салхи ихтэй үед 7 хоногт 3 удаа, тогтуун үед 2 удаа усалж байсан.
3	Уурхайн ажиллагсдад тоосноос хамгаалах хушуувч, амны маск, хүнсний нэмэлт бүтээгдэхүүнээр ажилчдыг хангах сургалт явуулах		150 000	100%	Уурхайн ажиллагсдад тоосноос хамгаалах хушуувч, амны маск, хүнсний нэмэлт бүтээгдэхүүнээр ажилчдыг хангаж сургалт явууллаа.
4	Уурхайн карьерт орж гарах машин, ачилт буулгалтын цаг хугацаа, хоорондын зайг тоосны сарнилтай	Дотоод тээврийн замын хүрээнд	-	100%	Уурхайн карьерт орж гарах машин, ачилт буулгалтын цаг хугацаа, хоорондын зайг уурхайн

**“БИ ЭС АЙ” ХХК-ИЙН БАЯНХОНГОР АЙМГИЙН ӨЛЗИЙТ СУМЫН НУТАГТ ОРШИХ “БАРУУН ХАРГАНТЫН” АЛТНЫ ШОРООН ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН  
2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ МЕНЕЖМЕНТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**



	ялдуулан оновчтой байлгах тооцоог хийж мөрдөж ажиллах				даргын удирлаган доор удирдуулан тээвэрлэсэн.
<b>Зам усалгаа</b>					
5	Зам усалгааны төлбөр төлөх			100%	Ус ашиглалтын гэрээний дагуу, ус ашигласны төлбөрөө төлсөн
6	Жолоочын цалин болоод бензиний төлбөр төлөх	Уурхайн ажилчидын хүрээнд		100%	Зам усалгааг хийсэн 23 жолоочийн цалинг сар бүрийн 15-нд цалингийн зардлаар тусган төлсөн.
<b>Усан орчинд үзүүлж буй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ</b>					
7	Ус ашиглуулах дүгнэлт Монгол усаар гаргуулах	Уурхайн усан хангамжийн хүрээнд	250 000	100%	“Монгол ус” ТӨҮГ-аар ус ашиглуулах дүгнэлтийг гаргуулсан.
8	Ахуйн бохир усыг цэвэршүүлэн ногоон байгууламжийн усалгаанд ашиглах, ажилчдад усыг хэмнэлттэй ашиглах талаар сургалт зохион байгуулах	Уурхайн усан хангамжийн хүрээнд	-	100%	Ажилчдад усаа хэрхэн хэмнэлттэй хэрэглэх талаар сургалт зохион байгуулсан
9	Физик хими, нянгийн бүрэн шинжилгээ, Хүнд металын шинжилгээ, БХХ болон цэвэршүүлсэн бохир усны стандартад заасан үзүүлэлтүүд	Уурхайн хүрээнд		100%	Унд ахуйн хэрэглээний усны шинжилгээг усны итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлсэн
10	Худгийг тоолууржуулах	Худаг		100%	Төслийн талбайд байрлах 2 худгийг паспортжуулсан, мөн тоолууржуулсан байна
11	Унд ахуйн зориулалттай худганд усанд эрүүл ахуй болон хамгаалалтын бүсийг тогтоож бүсэд мөрдөх журмыг сахиж ажиллана.	Худгийн хүрээнд	-	100%	Унд ахуйн усны хэрэглээний худгийг 50 метрээр хамгаалалтын зурвас татаж, тогтсон маршрутын дагуу ахуйн хэрэглээний усыг авдаг.
12	Аймгийн онцгой байдал, мэргэжлийн хяналтын газраас зохион байгуулсан сургалтанд суух.	“Би Эс Ай” ХХК	-	100%	Баянхонгор аймгийн Мэргэжлийн хяналтын газар, онцгой байдлын газраас зохион байгуулсан нөхөн сэргээлтийн сургалтын агуулгын дагуу уурхайн ажилчдад сургалт явуулсан.

**“БИ ЭС АЙ” ХХК-ИЙН БАЯНХОНГОР АЙМГИЙН ӨЛЗИЙТ СУМЫН НУТАГТ ОРШИХ “БАНУУН ХАРГАНТЫН” АЛТНЫ ШОРООН ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН  
2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ МЕНЕЖМЕНТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**



13	Худгийн усанд хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу шинжилгээ хийлгэх	Худгийн усны хүрээнд	150000	100%	Усны шинжилгээний газрын 2 худгийн 2 дээжинд хийлгэсэн.
<b>Газар болон хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай</b>					
14	Тос тосолгоо, сэлбэгийн агуулахыг байршуулж, тос асгаралтын үед шаардагдах элс зэргийг ойр байршуулна.		5 000 000	100%	Тос тосолгооны материал, сэлбэгийн агуулах, 40 тонны контейнер тус тусад нь байршуулсан. Элсийг агуулахад байршуулсан.
15	Засварын газраас өөр газарт тос масло асгарсан тохиолдолд асгарсан хэсгийг элс асгаж саармагжуулан бохирдсон хөрсийг авч хог хаягдал руу ачуулна.			100%	Тос масло асгарсан тохиолдолд шингээх элс, эсгийг авч байршуулсан.
16	Хүнд металлын шинжилгээ хийлгэх	Хөрсөн бүрхэвчийн хүрээнд	45000	100%	Хөрс судлалын итгэмжлэгдсэн лабораториор шинжилгээг хийлгэсэн.
<b>Ургамлан нөмрөг, амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай</b>					
17	Гал түймрийн аюулаас хамгаалж гал унтраах багаж хэрэгслийг хотхонд байрлуулна.	Уурхайн хүрээнд	350000	100%	Гал унтраах багаж хэрэгслийг хотхонд байршуулсан.
18	Орд орчмын ургамлын бүрхэц, зүйлийн бүрдлийн судалгаа хийх	Уурхайн хүрээнд		100%	Ургамлын зүйлийн бүрдлийг раменскийн тороор тоолж тодорхойлсон.
<b>Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлтийн тухай</b>					
19	Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт, Нинжа нарын гараар эвдэрсэн газарыг нөхөн дүүргэлт хийх, хог хаягдлыг цэвэрлэх	Уурхайн хүрээнд	10 000 000	-	2023 онд уулын ажилд 1.1 га талбайд олборлолт явуулж, 1.1 га талбайд техникийн нөхөн сэргээлт
<b>Хог хаягдлын менежментийн биелэлтийн тухай</b>					
19	Орон нутгийн иргэдийн санал, хүсэлтийг хүлээн авч нинжа нарын гараар эвдэрэн орхигдсон газарт очин хог хаягдлыг цэвэрлэх	Хог хаягдлын хүрээнд	350000	100%	Нинжа нарын гараар эвдэрэн орхигдсон газрын хог хаягдлыг өөрийн ажилчдаар цэвэрлүүлсэн байна. Хавсралт зургаар үзүүлэв.
20	Ахуйн хатуу хог хаягдлаа төрөлжүүлэн ялган хаях хогийн савнуудыг худалдан авч хог хаягдлын төрлийг хогийн савны гадна бичиж байрлуулна.	Хог хаягдлын хүрээнд	160000	100%	Хатуу хог хаягдлыг хийх 4ш хогын сав худалдан авсан.



**“БИ ЭС АЙ” ХХК-ИЙН БАЯНХОНГОР АЙМГИЙН ӨЛЗИЙТ СУМЫН НУТАГТ ОРШИХ “БАРУУН ХАРГАНТЫН” АЛТНЫ ШОРООН ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН  
2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ МЕНЕЖМЕНТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**



21	Шингэн хаягдал хөрс болон гүний усыг бохирдуулж байгаа эсэхийг шалгаж биологийн болон химийн шинжилгээ хийлгэнэ.	Хог хаягдлын хүрээнд	150000	100%	Хөрс судлалын итгэмжлэгдсэн лабораториор шинжилгээг хийлгэсэн.
22	Зуны улиралд хогийн сав болон ажилчдын амьдрах байр, гал тогоонд хортон шавьжийн ариутгал халдваргүйжүүлэлт хийлгэх	Хог хаягдлын хүрээнд	400000	100%	Баянхонгор аймгийн гоц халдвартын төвөөр хийлгэсэн.
23	Ахуйн бохир ариутгах, халдваргүйжүүлэх, задлах бодис худалдаж авах зардал		450000	100%	Ахуйн бохир ариутгах, халдваргүйжүүлэх бодис худалдаж авсан.
24	Дахин ашиглагдах түүхий эдийг ялган тушаах	Хог хаягдлын хүрээнд	Үйл ажиллагааны зардалд орсон.	100%	Ундаа, усны савыг ялган улаанбаатар хотод дахин боловсруулах үйлдвэрт авчирч тушаасан.
25	Гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх зорилгоор галын хор тавих	Уурхайн хэмжээнд		100%	Уурхайд галын хор байршуулсан ,галын сараа хийсэн.
<b>Түүх, соёлын өвийг хамгаалах тухай</b>					
26	Төсөл хэрэгжиж буй талбайд шинээр археологи, палентологийн олдвор гарсан тохиолдолд мэргэжлийн байгууллагуудтай хамтран нүүлгэн шилжүүлэх, музей эсвэл эрх бүхий төрийн байгууллагад шилжүүлэх				Уурхайн талбайд археологи, палентологийн олдвор олдоогүй.
<b>Тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулах тухай</b>					
27	Байгаль орчныг хамгаалах, үйлдвэрлэлийн осол, гал түймэр, усны аюул мэтийн гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах талаар 1 жилд 2 удаа сургалт, сурталчилгааны ажлыг мэргэжлийн байгууллага хүмүүстэй хамтран зохион байгуулна.	Уурхайн ажилчдын хүрээнд	-	100%	Гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэх тухай сургалтыг Баянхонгор аймгийн Өлзийт сумын онцгой байдлын газартай хамтран сургалт семинар хийсэн.

**“БИ ЭС АЙ” ХХК-ИЙН БАЯНХОНГОР АЙМГИЙН ӨЛЗИЙТ СУМЫН НУТАГТ ОРШИХ “БАРУУН ХАРГАНТЫН” АЛТНЫ ШОРООН ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН  
2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ МЕНЕЖМЕНТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

35	Байгаль хамгаалах талаар хийсэн ажлын жил бүрийн тайланг БОАЖЯ болон Өлзийт сумын ЗДТГ-т хүргэн өгч байна.	“Би Эс Ай” ХХК	-	100%	БОАЖЯ-аар БОМТ-г батлуулан 1 хувийг хүргэсэн бөгөөд батлагдсан БОМТ-ийг хүргүүлсэн.
36	Байгаль хамгаалахад орон нутгийн иргэдийн оролцоог идэвхижүүлэх, уулзалт зөвлөлгөөг жил бүр зохион байгуулах, тэдний санал зөвлөмжийг БОМТ-г хэрэгжүүлэх ажилд тусгах	“Би Эс Ай” ХХК	350000	100%	Орон нутгийн иргэдтэй нээлттэй харилцан тэдний саналын БОМТ-нд тусгасан.
37	Баянхонгор аймгийн Өлзийт сумтай хамтын ажиллагааны гэрээ хийх	“Би Эс Ай” ХХК	-	100%	Өлзийт сумын засаг даргатай хамтын ажиллагааны гэрээг хийсэн. Хавсралтаар оруулав.
<b>Орчны хяналт шинжилгээний тухай</b>					
38	Усан орчинд рН, цахилгаан дамжуулах чадвар нүүрстөрөгчийн исэл СО3, хүчил НСО3, кальци Са, хлор Cl, кали К, магни Mg, сод Na, хүхэр S, хүнцэл As, бор В, бари Ва, кадми Cd, кобальт Со, хром Cr, зэс Си, төмөр Fe, мөнгөн ус Hg, манган Mn, молебдин Мо, никель Ni, хар тугалга Pb, селени Se, силиконSi, ванади V, цинк Zn, хөнгөн цагаан Al, мөнгө Ag, Хими бактериологийн бүрэн шинжилгээ.	Усан орчин	30000	100%	Хөрс, усны итгэмжлэгдсэн лабораториор шинжилгээг хийлгэсэн.
39	Хөрсний механик бүрэлдхүүн, ялзмаг, кадми Cd, кальци Са, зэс Си, хүнцэл As, мөнгөн ус Hg, кобальт Со, никель Ni, хар тугалга Pb, сод Na, магни Mg, төмөр Fe, цинк Zn, сульфат SO4, хүчил саармагжуулах чадвар, хүчил үүсгэх чадвар ANP/AGP, чулуулгийн найрлага ABA, нийт сульфит Total Sulfur, ялгардаггүй сульфат S N-Ex, пиритийн сульфит P-Sulfur, рН	Хөрсөн бүрхэвч	30000	100%	Хөрс судлалын итгэмжлэгдсэн лабораториор шинжилгээг хийлгэсэн.

**“БИ ЭС АЙ” ХХК-ИЙН БАЯНХОНГОР АЙМГИЙН ӨЛЗИЙТ СУМЫН НУТАГТ ОРШИХ “БАРУУН ХАРГАНТЫН” АЛТНЫ ШОРООН ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ МЕНЕЖМЕНТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

40	Хөрсний хүнд металлын шинжилгээ хийлгэх	Хөрсөн бүрхэвч	45000	100%	“Хөрс судлалын итгэмжлэгдсэн лабораториор шинжилгээг хийлгэсэн.
<b>Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах тухай</b>					
41	Уурхайн үйл ажиллагаатай сум орон нутгийн иргэд, ЗДТГ-ын мэргэжилтэн, холбогдох мэргэжлийн газар дээр нь танилцуулах	“Би Эс Ай” ХХК	-	100%	Сум орон нутгийн иргэд, ЗДТГ-ын мэргэжилтэнд танилцуулсан.
<b>Нийгмийн хариуцлагын хүрээнд</b>					
42	Баянхонгор аймгийн хот тохижилтын үйл ажиллагааг хийх, Өлзийт сумын ард иргэдэд нийгмийн хариуцлага хүлээж мөн хандив, тусламж үзүүлэх	“Би Эс Ай” ХХК	2023 онд 15 000 000	100%	Орон нутагтай хамтран ажиллах гэрээний дагуу 2023 онд гэрээ хийж үүнээс 15.0 төгрөгийн ажлыг хийж гүйцэтгэсэн байна. Баянхонгор аймгийн Тамгын газрын гаднах тохижолтын ажлыг хийж өгсөн.